



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 02 сарын 17-өдөр

Дугаар 4179

Булган сум

Шинээр амаржсан эх, хүүхдүүдэд хүндэтгэл
үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дүгээр зүйлийн 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шинэ оны босгон дээр Булган нутагт шинээр амаржсан эх, хүүхдүүдийг эргэн шинэ оны мэндчилгээ дэвшүүлэн хүндэтгэл үзүүлсүгэй.


2. Хүндэтгэлийн зардалд шаардлагатай 2,320,000 (хоёр сая гурван зуун хорин мянган) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 20.45 оны
02 дугаар сарын 12-ны/ний өдрийн ... 4/39 дүгээр
захирамжийн хавсралт



Шинээр амаржсан эх, хүүхдүүдэд хүндэтгэл
үзүүлэхэд шаардагдах зардал

д/д	Зориулалт	Тоо/ш	Үнэ	Нийт
1	2	3	4	5
1	Нярайн багц	16	145,000	2,320,000